COMPLEX

Mongol NFT

www.complex.mn

www.mongolnft.com

Комплекс Дижитал Экосистем ХХК

Үйл ажиллагааны тайлан 2024 он

2024/01/01 - 2024/12/31

АГУУЛГА

Санхүү	3
Бүтээгдэхүүн & Үйлчилгээ	12
Эрсдэлийн удирдлага	14
Систем	16
Аудит	19

САНХҮҮ

ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР, ТӨРЛҮҮД

Орлогын эх үүсвэр

- Банкны зарлагын шимтгэл 1%, арилжааны шимтгэл дотоод койн 0.17%, гадаад койн 0.20%
- USDT /Tether/ урьдчилсан захиалга, шууд хөрвүүлэг
- НФТ дроп анхдагч арилжааны орлогоос шимтгэл (MNT болон MNFT)
- Хоёрдагч зах зээлийн арилжааны шимтгэл (Бүтээл гаргагч&Платформ MNFT- 10%, MNT-5%)

Орлогод нөлөөлсөн хүчин зүйлс

- 2022 онд BXYY-н тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш дотоодын шинэ койн 2024 онд лист хийгдээгүй.
- Дотоод койны зах зээлийн эрэлт, хэрэгцээ арилжаа нь 2022 оноос хойш эрчимтэй буурч, арилжааны зогсонг байдал орлогод шууд нөлөөлж байна.

ӨР ТӨЛБӨРИЙН ХАРЬЦАА БА САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖ

Өр төлбөрийн харьцаа = Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө

- Комплекс Дижитал Экосистем ХХК-ийн 2024 оны аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр өр төлбөрийн харьцаа **0.76** буюу нийт хөрөнгө нь өр төлбөрөөс **31%**-иар илүү байна.
- Нийт өр төлбөрийн 98% нь харилцагчийн хэтэвчийн дүн болж өссөн шалтгаан нь **USDT урьдчилсан захиалгын үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой.** Тус үйлчилгээ нь харилцагчийн хэтэвчний дүнг нэмэгдүүлэх гол үндэслэл болсон ба уг богино хугацаат өр төлбөрийг ажлын 3-5 хоногт төлж барагдуулдаг болно.
- Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдээс (Хязгааргүй Шийдэл ХХК, Bittrex Global GmbH) санхүүжилт татах боломжтой.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ЭСВЭЛ ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Сонирхлын зөрчил болон их хэмжээний хэлцэл байхгүй

COMPLEX.MN ХАДГАЛЖ, УДИРДАЖ БАЙГАА ХАРИЛЦАГЧИЙН ВИРТУАЛ БОЛОН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дотоод койн/токен эзэмшиж буй харилцагч нарийн нийт хөрөнгө (MNT)	~5,481,723,590.65
Гадаад койн/токен эзэмшиж буй харилцагч нарийн нийт хөрөнгө (MNT)	~4,202,023,100

MONGOLNFT.COM ХАДГАЛЖ, УДИРДАЖ БАЙГАА ХАРИЛЦАГЧИЙН ВИРТУАЛ БОЛОН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Харилцагчийн Мөнгөн хөрөнгө (MNT)	~111,742,169.25
Харилцагчийн Виртуал хөрөнгө (MNT)	~1,417,872,980.8

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар.

САНХҮҮ

INTER AUDIT

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Комплекс Дижитал Экосистем" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК

САНХҮҮ

АГУУЛГА

I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.07.30

САНХҮҮ

“КОМПЛЕКС ДИЖИТАЛ ЭКОСИСТЕМ” ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР:	“Комплекс Дижитал Экосистем” ХХК
РЕГИСТРИЙН ДУГААР:	6719791
КОМПАНИЙН УДИРДЛАГА:	Ч.Ганбаатар
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
КОМПАНИЙН ХАЯГ:	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр–2, 402 тоот
УТАС:	72775050

АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

INTER AUDIT

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.04.30

АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

САНХҮҮ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 1

"Комплекс дижитал экосистем" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

САНХҮҮ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"КОМПЛЕКС ДИЖИТАЛ ЭКОСИСТЕМ" ХХК-ИЙН УДИРДЛАГАД

ДҮГНЭЛТ

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Комплекс дижитал экосистем" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар "Комплекс дижитал экосистем" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартындагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

БУСАД АСУУДАЛ

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд ямар нэг баталгаа илэрхийлээгүй.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.04.30

САНХҮҮ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөртүвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

1. Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүйбайх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
2. Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.
3. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

4 Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх ньхангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог.

Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

5 Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Хүндэтгэсэн, "ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.МӨНХБАЯР

Тайлангийн огноо: 2025/04/30

ИНТЕР АУДИТ ХХК

САНХҮҮ

Аудитлагдсан санхүү байдлын тайлан

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Эргэлтийн хөрөнгө	927,654,543.34	3,795,539,298.02
Эргэлтийн бус хөрөнгө	1,626,324,978.78	1,720,345,506.89
Нийт хөрөнгийн дүн	2,553,979,522.12	5,515,884,804.91
Богино хугацаат өр төлбөр	957,077,430.80	4,167,665,917.71
Урт хугацаат өр төлбөр	913,814.71	913,814.71
Эздийн өмч	1,595,988,276.61	1,347,305,072.49
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,553,979,522.12	5,515,884,804.91

Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Хүүний орлого		5,098,719.47
Бусад орлого	134,692,136.83	424,300.00
Борлуулалт, маркетингийн зардал	7,827,000.00	9,921,423.17
Ерөнхий ба удирдлагын зардал	809,826,899.72	468,993,855.89
Санхүүгийн зардал		55,923,294.52
Бусад зардал	24,502,264.69	8,405,815.92
Ханшийн зөрүүний олз (гарз)	416,619.17	160,157,718.82
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(517,501,462.85)	(285,962,236.22)
Орлогын татварын зардал	215,387.82	513,125.64
Татварын дараах ашиг (алдагдал)	(517,716,850.67)	(286,475,361.86)
Бусад дэлгэрэнгүй орлого	(5,301,490.59)	37,956,214.89

НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	(523,018,341.26)	(248,519,146.97)

САНХҮҮ

Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн /мян.төг/
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	2,000,000.00	(197,642,898.87)	422,396,008.51	2,224,753,109.64
Тайлант үеийн цэвэр ашиг алд			(517,716,850.67)	(517,716,850.67)
Бусад дэлгэрэнгүй орлого		(5,301,490.59)		
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	2,000,000.00	(77,873,238.41)	(326,138,484.98)	1,595,988,276.61
Тайлант үеийн цэвэр ашиг алд			(286,475,361.86)	
Бусад дэлгэрэнгүй орлого		37,956,214.89		
2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	2,000,000.00	(39,917,023.52)	(612,777,903.99)	1,347,305,072.49

Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	5,608,681,145.05	18,872,754,416.16
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	6,063,160,945.72	15,439,541,872.64
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(454,479,800.67)	3,433,212,543.52
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	209,325,073.09	197,750,887.26
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	335,508,074.88	472,499,340.13
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(126,183,001.79)	(274,748,452.87)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	69,286,585.89	1,341,361,025.81
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага		2,015,935,793.70
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	69,286,585.89	(674,574,767.90)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(511,376,216.57)	2,483,889,322.74
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	925,752,993.74	414,376,777.17
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	414,376,777.17	2,898,266,099.92

Шинээр гаргасан бүтээгдэхүүн, үйлчилгээ

USDT pre-order
/Tether урьдчилан захиалах үйлчилгээ/
2024.10.07

Шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт

Шууд хөрвүүлэг
/MNT-USDT, USDT-MNT/
2024.01.01

USDT staking
/USDT стэйк хийж койноор өгөөж хүртэх/
2024.09.25

ШИНЭ НФТ ДРОПУУД

1. MongolNFT app

2024/12 сар
MongolNFT app ашиглалтад орсон.
Зорилго: Хэрэглэгч нарт үйл ажиллагаагаа илүү ойр болгох, MongolNFT платформыг хэрэглэхэд хялбар болгох үүднээс MongolNFT app-ийг ашиглалтад оруулав.

2. Баян Монгол НФТ

2024/07 сар
"Баян Монгол" дижитал арт НФТ-ийн 7 иж бүрдлийг бүгдийг нь анхдагч зах зээлээс худалдан авч эзэмшсэн хүн уг "Баян Монгол керамик уран баримлын чуулбар"-ыг биетээр нь авах NFT гаргасан.
**чуулбар~ хөшөө, дурсгал*

3. https://cstore.mongolnft.com/

2024/06 сар
https://cstore.mongolnft.com/ ашиглалтад орсон.
Зорилго: Хамтран ажилладаг байгууллагууд болон MongolNFT-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах боломжтой хөнгөлөлтийн НФТ-ийг борлуулах зорилготой.

4. Greed of Ethereum НФТ

2024/05 сар
Тус НФТ нь арт-уран бүтээл зорилгоор гарсан ба дагалдах амлалт байхгүй, НФТ-ээс орох орлого нь бүтээл гаргагчийн дараагийн уран бүтээл хөгжүүлэлтэд зарцуулагдсан.

5. Ethereum сүлжээ минтинг

2024/04 сар
The Wolves НФТ-ийг Ethereum сүлжээ дээр лист хийв.
Зорилго: The Wolves НФТ-ийг олон улсын хэрэглэгч нарт таниулах, олон улсын НФТ зах зээл дээр арилжих боломжийг нэмэгдүүлэг зорилгоор ихэнх алдартай НФТ цуглуулагч нарын ашигладаг Ethereum сүлжээ дээр The Wolves НФТ-ийг лист хийсэн болно.

6. https://dragon.mongolnft.com/

2024/04 сар
https://dragon.mongolnft.com/ нээгдсэн.
Зорилго: Dragon NFT авсан эзэмшигч нар танин мэдэхүйн сонирхолтой тоглоомууд тоглон, даалгавар биелүүлснээр шагнал авах боломжтой тоглоомын платформ бүтээв.

7. Dragon Asset НФТ

2024/04 сар

Dragon Asset NFT.
Зорилго: Dragon verse платформ дээр энэхүү НФТ-ээ ашиглан даалгавар биелүүлж шагнал авах боломжтой платформ бүтээв.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Комплекс Дижитал Экосистем ХХК нь 2019 онд Bitmonex нэрээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба тухайн үед Монголын хоёр дахь виртуал хөрөнгийн бирж болж байсан ба 2021 онд “Rebranding” хийснээр брэнд нэрээ “Complex.mn” болгон өөрчилж, дэлхийн бодит цагийн ханшаар гадаад криптовалютаар Монголоос арилжаанд оролцох боломжийг харилцагч нартаа олгосон билээ.
- 2021 онд MNFT, IHC, OBOT болон ZES зэрэг дотоодын 5 криптовалютын IEO-г амжилттай хийж гүйцэтгэсэн ба одоогийн байдлаар Complex.mn бирж дээр дотоод, гадаадын нийт 60 гаруй криптовалют арилжаалагдаж байна.
- 2021 оноос Монгол НФТ платформын цэс ашиглах түрээсийн гэрээ байгуулж, тус платформ дээр одоогийн байдлаар 74 бүтээл гаргагч нарын 61,175 ширхэг НФТ бүтээл лист хийгдсэн байна.
- Техникийн аюулгүй байдлыг #1-т тавьж, 2022 оноос мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO27001:2013 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.
- Комплекс Дижитал Экосистем ХХК нь 2022 оны 10 сарын 10-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороонд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлснээр дараах хууль тогтоомж болон бодлого, журмыг дагаж мөрдөн ажиллаж байна. Үүнд:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль
2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам
3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам

Компанийн дотоод нэгж, зохион байгуулалт:
1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ хариуцсан нэгж
2. Хууль&Комплаенс
3. Мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгж
4. Санхүү, хөрөнгийн бүртгэл хариуцсан хариуцсан нэгж
5. Харилцагчийн үйлчилгээ хариуцсан нэгж
6. Маркетинг
7. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ/ҮЙЛ АЖИЛЛАГААНД

“Комплекс Дижитал Экосистем” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн Эрсдэлийн үнэлгээний аргачлалын зорилго нь учирч болзошгүй аюулаа урьдчилан судалж, үнэлж, аюул ба эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж, түүнд хяналт тавьж, үнэлж, тасралтгүй сайжруулалт хийх зарчмаар Компани болон Харилцагч талд ирээдүйд үүсэх аливаа гэнэтийн аюул ба эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсхүл хамгийн бага түвшинд байлгахад зорин ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээний явцад дараах аргачлал, асуумж болон эрсдэлийг хөтлөх үйл ажиллагааг баримтална. Үүнд:

Байгууллагад үзүүлсэн нөлөөллийн үнэлгээ:

Байгууллагад үзүүлсэн нөлөө	Rating	Value
One Function impacted/Нэг нэгжид нөлөөлсөн	Бага	1
One Person or Process impacted/Нэг хүн эсвэл нэг процессд нөлөөлсөн	Бага	1
Small Financial Loss/Бага хэмжээний санхүүгийн алдагдал	Бага	1
Some Downtime or Outage in Service/Хэсэг хугацааны зогсолт, тасалдал	Бага	1
Impact on Client Service or Contract/Харилцагчийн үйлчилгээ эсхүл гэрээнд нөлөөлөх	Дунд	2
Considerable Financial Loss occurred/Мэдэгдэхүйц хэмжээний санхүүгийн алдагдал тохиолдсон	Дунд	2
Breach of Contract or SLA/Гэрээ эсвэл SLA зөрсөн	Дунд	2
Data Breach or Incident /Өгөгдөл алдагдах эсвэл эрсдэлийн тохиолдол	Дунд	2
Minor impact on Company Brand, Image, Goodwill/Компанийн брэнд, нэр хүнд, үнэ цэнэд бага хэмжээгээр нөлөөлөх	Дунд	2
Breach of Internal Policy or Process or Code/Дотоод бодлого, процесс эсвэл кодыг зөрчих	Дунд	2
Impact on Multiple Functions or Processes/Хэд хэдэн нэгж эсвэл процессд нөлөөлөх	Дунд	2
Considerable impact on Service Delivery/ Үйлчилгээнд мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөөлөх	Дунд	2
Impact on Supplier or Service Provider/Нийлүүлэгч эсвэл үйлчилгээ үзүүлэгчид нөлөөлөх	Дунд	2
Impact on Entire Organization/Нийт байгууллагад нөлөөлөх	Өндөр	3

Impact on entire Product or Service Delivery/Нийт бүтээгдэхүүн болон үйлчилгээнд нөлөөлөх	Өндөр	3
High or Major Financial Loss/Өндөр эсвэл их хэмжээний санхүүгийн алдагдал	Өндөр	3
Breach of Legal or Statutory or Regulatory compliance/Хуулийн, эрх зүйн болон эрх бүхий байгууллагын шаардлагыг зөрчих	Өндөр	3
Major Downtime or Outage/Урт хугацааны зогсолт, тасалдал	Өндөр	3
Personal Data or PII Breach/Хувийн мэдээлэл эсвэл хувийн эмзэг мэдээлэл алдагдах	Өндөр	3

Нийт нөлөөллийн үнэлгээний тооцоолол:

Нийт нөлөөллийн үнэлгээ	(Нууцлалд үзүүлэх нөлөө + Бүрэн бүтэн байдалд үзүүлэх нөлөө + Хүртээмжтэй байдалд үзүүлэх нөлөө) x (Байгууллагад үзүүлэх нөлөө)

Магадлал эсвэл Боломж	Rating	Value
No possibility of happening/ Тохиолдох боломжгүй	Бага	1
Not happened in past - not likely to happen in future / Өнгөрсөн хугацаанд тохиолдож байгаагүй - ирээдүйд тохиолдох магадлал маш бага	Бага	1
Possible - as happened with others / Тохиолдох боломжтой - бусад байгууллагад тохиолдож байсан	Дунд	2
Has happened in past - some times /өнгөрсөн хугацаанд тохиолдсон - заримдаа	Дунд	2
Likely to happen / Тохиолдох боломжтой	Дунд	2
Not happened in past - but may happen in future / Өнгөрсөнд тохиолдож байгаагүй - гэхдээ ирээдүүйд үйд тохиолдох боломжтой	Дунд	2
Almost certain to happen / Тохиолдох магадлал өндөр	Өндөр	3
Happens every now and then / Тогтмол тохиолддог	Өндөр	3
Has happened in past - many times / Өнгөрсөн тохиолдож байсан - олон удаа	Өндөр	3

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Комплекс Дижитал Экосистем ХХК-ын Эрсдэлийн удирдлагын журам, Дотоод аудиторын зөвлөмж дагуу дараах хугацаанд компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн хяналт хийж, бүртгэн, зөвлөмж гарган бууруулах чиглэлд ажиллав. Үүнд:

- 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр Хуваарьт эрсдэлийн үнэлгээ хийсэн.
- 2024 оны 7-8 саруудад API нийлүүлэгч гадаадын бирж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үйл ажиллагаа ба нэгжүүдэд учирч болзошгүй 3 эрсдэлийг тодорхойлж нэмж бүртгэн эрсдэлийн үнэлгээ хийв.

Тайлант жилд компанийн 7 нэгж, үйл ажиллагаанд МАБ-ын стандартын 112 эрсдэлийн дахин үнэлгээ хийгдэж, 60 эрсдэлийг үр дагаврыг ажиглах шаардлагатай, 52 эрсдэл хаагдсан байна.

2024 онд нийлүүлэгч гадаадын бирж өөрчлөгдсөнтэй холбоотой учирч болзошгүй 3 эрсдэл мөн хүний нөөцтэй холбоотой 3 эрсдэл нэмж бүргэгдэн нийт 6 эрсдэлээс 4 эрсдэл хугацаандаа хаагдаж, 2 эрсдэл нээлттэй үлдсэн байна.

Компанийн хэмжээнд эрсдэлийн дундаж үзүүлэлт 3,35 буюу дунд түвшинтэй үнэлэгдсэн болно.

Эрсдэлийн дундаж үзүүлэлт			
Severity	**Бага**	**Дунд**	**Өндөр**
Дундаж үзүүлэлт		3.35	

ВЕБ ДЭЭР ХИЙСЭН ЭМЗЭГ БАЙДЛЫН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГ

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Веб эмзэг байдлын шалгалт-01
Аудитын хугацаа	2024 оны 07 сарын 16
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Complex.mn

Веб эмзэг байдлын шалгалт-01					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	2	0	0

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Веб эмзэг байдлын шалгалт-02
Аудитын хугацаа	2024 оны 10 сарын 03
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Complex.mn

Веб эмзэг байдлын шалгалт-02					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	2	2	0	0

Веб эмзэг байдлын шалгалт-03	
Аудитын төрөл	Веб эмзэг байдал шалгалт-03
Аудитын хугацаа	2025 оны 01 сарын 07
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Complex.mn

Веб эмзэг байдлын шалгалт-03					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	2	2	0	0

ВЕБ ДЭЭР ХИЙСЭН НЭВТРЭХ ШАЛГАЛТЫН ЭМЗЭГ БАЙДЛЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГ

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Нэвтрэх шалгалтын эмзэг байдал шалгалт-01
Аудитын хугацаа	2024 оны 08 сарын 31
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Complex.mn

Нэвтрэх шалгалтын эмзэг байдлын шалгалт-01					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	0	0	2

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Нэвтрэх шалгалтын эмзэг байдал шалгалт-02
Аудитын хугацаа	2024 оны 10 сарын 14
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Complex.mn

Нэвтрэх шалгалтын эмзэг байдлын шалгалт-02					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	0	0	1

ЭМЗЭГ БАЙДЛЫН ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ

Эмзэг байдлыг үнэлэхдээ, CVSS[1] үнэлгээний аргыг ашигласан бөгөөд харгалзах тайлбарыг доорх хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт-1. Эмзэг байдлын үнэлгээ

Хохирол	CVSS V3 Score Range	Утга
Critical	9.0-10.0	Эмзэг байдлыг ашиглан халдлага үйлдвэл системийн түвшинд нөлөөлөх эсвэл хэрэглэгчийн хувийн мэдээллийг алдах ба халдлагыг хэрхэн үйлдэх логик нь энгийн, ойлгомжтой. Энэ төрлийн эмзэг байдалд **нэн яаралтай** арга хэмжээ нь зөв.
High	7.0-8.9	Эмзэг байдлыг ашиглан халдлага үйлдвэл системийн түвшинд нөлөөлөх (privilege escalation, data loss, downtime etc) эсвэл хэрэглэгчийн хувийн мэдээллийг алдах ба халдлагыг хэрхэн үйлдэх логик нь төвөгтэй, хэцүү. Энэ төрлийн эмзэг байдалд **боломжит яаралтай** хугацаагаар арга хэмжээ нь зөв.
Moderate	4.0-6.9	Эмзэг байдлыг шууд ашиглан халдлага хийх боломжгүй эсвэл урьдач нөхцөл шаардагддаг (social engineering etc). Энэ төрлийн эмзэг байдлыг **Critical болон High түвшний эмзэг байдлыг засаж дуусмагц**, яаралтай арга хэмжээ авах нь зөв.
Low	0.1-3.9	Эмзэг байдлыг ашиглан халдлага үйлдэх бараг боломжгүй боловч байгууллагын халдлагын гадаргуу (attack surface)-г нэмэгдүүлдэг. Энэ төрлийн эмзэг байдлыг **дараагийн төлөвлөгөөт засвар**таа нэгтгэн засварлах нь зөв.
Informational	N/A	Нэвтрэх эрхийн шалгалтын үед илэрсэн нэмэлт мэдээллүүд (системийн бичиг баримт, тохиргоо зэрэг). Үүнийг ашиглан халдлага үйлдэх боломжгүй.

Комплекс Дижитал Экосистем ХХК-ийн Complex.mn дэд болон үндсэн домэйн хаягууд дээр байршиж буй веб дээр эмзэг байдлын шалгалтуудыг тайлант жилд давтамжтай хийж, эмзэг байдлын шалгалтын үр дүнг тухайн бүрд холбогдох алба нэгжийн удирдлагад зөвлөмж хүргүүлж, засаж сайжруулж байсан ба ноцтой нөлөөлөх алдаа илрээгүй.

ВЕБ ДЭЭР ХИЙСЭН ЭМЗЭГ БАЙДЛЫН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГ

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Эмзэг байдал шалгалт-01
Аудитын огноо	2024 оны 07 сарын 16
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Mongolnft.com

Эмзэг байдлын шалгалт-01					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	2	0	0

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Эмзэг байдал шалгалт-02
Аудитын огноо	2024 оны 10 сарын 03
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Mongolnft.com

Эмзэг байдлын шалгалт-02					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	4	0	0

Тайлангийн хураангуй	
Аудитын төрөл	Эмзэг байдал шалгалт-02
Аудитын огноо	2024 оны 03 сарын 16
Боловсруулсан	Хязгааргүй Шийдэл – Мэдээллийн аюулгүй байдлын баг
Байгууллага	Комплекс Дижитал Экосистем ХХК/Mongolnft.com

ВЕБ ДЭЭР ХИЙСЭН НЭВТРЭХ ШАЛГАЛТЫН ЭМЗЭГ БАЙДЛЫН ТАЙЛАН

Нэвтрэх шалгалтын эмзэг байдлын шалгалт-01					
Severity	Critical	High	Medium	Low	Informational
# of issues	0	0	0	0	0

ВЕБ ЭМЗЭГ БАЙДЛЫН ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ

Комплекс Дижитал Экосистем ХХК-ийн Mongolnft.com платформын дэд болон үндсэн домэйн хаягууд дээр байршиж буй веб дээр эмзэг байдлын шалгалтуудыг тайлант жилд давтамжтай хийж, эмзэг байдлын шалгалтын үр дүнг тухайн бүрд холбогдох алба нэгжийн удирдлагад зөвлөмж хүргүүлж, засаж сайжруулж байсан ба ноцтой нөлөөлөх алдаа илрээгүй ба нэвтрэх шалгалтын эмзэг байдал тайлант жилд илрээгүй болно.

ДОТООД АУДИТ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДҮГНЭЛТ 2024 ОН

2024 ОНЫ 09-Р САРЫН 03

1	**Аудитын нэр, код**	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-ны ISO/IEC 27001:2013 стандартын дотоод аудит
2	**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**	Дотоод аудитын журмын дагуу
3	**Аудитын хамрах хүрээ**	ISO/IEC 27001:2013 стандартын хэрэгжүүлэлтийн хамрах хүрээг бүхэлд нь багтаах буюу “Комплекс Дижитал Экосистем” ХХК бүх үйл ажиллагаа, нэгжүүд хамаарна.
4	**Аудитын зорилт**	ISO/IEC 27001:2013 стандартын дагуу МАБМТ-ны хэрэгжүүлэлтийн үр дүнтэй байдлыг шалгах зорилготой.
5	**Үндсэн мэдээлэл**	“Комплекс Дижитал Экосистем” ХХК ISO/IEC 27001:2013 стандартыг 2022-онд нэвтрүүлсэн бөгөөд хэрэгжүүлж байгаа энэхүү стандартын хүрээнд МАБМТ-ны хэрэгжилтийн дотоод хяналт шалгалтыг хийж, үр дүнг удирдлагад мэдээлнэ.
6	**Аудитын арга зүй**	2 шаттайгаар дотоод аудитыг хэрэгжүүлнэ. 1-р шатанд бичиг баримтын хяналтыг биечилсэн уулзалт ярилцлага хэлбэрээр хийнэ. 2-р шатанд ярилцлага, ажиглалт, болон техникийн тулган шалгах аргачлалаар биечилсэн хяналтыг хэрэгжүүлнэ. Ингэхдээ урьдчилан бэлтгэсэн аудитын шалгах хуудасны дагуу стандартын шаардлагуудтай холбоотой асуулгыг ашиглана.
7	**Аудитад ашиглах шалгуур, үзүүлэлт**	ISO/IEC 27001 стандартын 2013 оны хувилбарын үндсэн 4-10 болон хавсралт 2-1А дэх 112 контролын дагуу.

Аудитын дүгнэлт:

Дотоод аудитын шалгалтаар Үл нийцэл буюу залруулах шаардлагатай ажлын санал байхгүй, Сайжруулах ажлын санал 3 гаргаж холбогдох удирдлагуудад тайлагнаж, нэгжийн хариуцсан ажилтнуудад мэдэгдэл хүргүүлсэн болно.

Сайн туршлага, тохирол:
МАБ-н холбогдох бодлого журмууд боловсруулагдсан.
Стандартын хэрэгжүүлэлт нь хуулийн шаардлагын хүрээнд тавигдсан бөгөөд дээд удирдлагын зүгээс МАБУТ-ны хэрэгжүүлэлтийг дэмжиж, шаардлагатай нөөц эх үүсвэрээр хангаж, хэрэгжүүлэлтийн баг томилогдсон.
Хүний нөөцийн аюулгүй байдлын хяналтууд сайн хэрэгждэг ба хүний нөөцөөс үүсэж болох эрсдэлээ тодорхойлж тухай шинэчилж шаардлагатай арга хэмжээ авагдсан.
Нууцын гэрээнүүд хийгддэг.
МАБ-н сургалт тогтмол хийгддэг.
Өмнөх оны аудитын дүгнэлтийн хэрэгжилт сайн хийгдсэн.
Веб эмзэг байдлын үнэлгээний шалгалт, нэвтрэх шалгалтын эмзэг байдлын шалгалтууд хийгдсэн дүгнэлт гарч зөвлөгөө зөвлөмж өгч, сайжруулалт хийгдсэн байна.

ГАДААД АУДИТ

ГАДААД АУДИТЫН ДҮГНЭЛТ 2024 ОН

2024 ОНЫ 09-Р САРЫН 13

BQSR	**CERTIFICATION AUDIT REPORT** ***ISO 27001:2013 (ISMS)***	**Work Order Nr.:** **Page:** 25/28

____No___Minor Non conformance identified in the Surveillance audit, details of Non Conformance in CAR From (BQSR FM-058A) *(Note: The detailed NC is to be submitted and accepted by the client on BQSR-FM-058A)*

Summary of Audit

The Stage-2 Certification audit of Complex Digital has provided adequate conformance to the requirements of ISO 27001:2013 standard for Information Security Management System. The System planned, defined and implemented by the Organization was found to be satisfactory and certain practices followed by Organization were appreciable. Some findings were identified during interactions with various Departments which were briefed to the concerned auditees and recorded in this report wherever deemed necessary. The overall implementation was found satisfactory and providing the conformity to the requirements laid down by ISO 27001:2013 standard. Hence, I am pleased to recommend for the certification to the Organization for ISO 27001:2013.

	Initial certification – Initial Certification
	Post audit
Yes	Surveillance Cum Transfer
	Modification
	Renewal
	Upgrade from
	other :

Yes	Issuance of the certificate
	use of the BQSR Logo as per Guidance for Usage of Logo
	refusal of the certificate
	post audit
	modification of the current certificate (registration and expiration date remain unchanged)
	other :

	The information system complies with the requirements of the reference standard: Congratulations, on the basis of the above summary, Lead Auditor is pleased to put forward a recommendation for certification.
	The quality system complies with the requirements of the reference standard with exception of minor NC: NA
	Exception of major non conformities: NA.
	Not Recommended: NA
Proposed Audit Date for Surveillance Audit on or before	*30/08/2025*

ГАДААД АУДИТ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМИЙН СТАНДАРТЫН СЕРТИФИКАТ 2024-2025 ОН

has been assessed and found to conform to the requirements of

ISO/ IEC 27001:2013

Information Security Management System

This Certificate is valid for the following scope:

Exchange (fiat, cryptocurrency and all other virtual assets), Transfer, Safekeeping, Staking, Lending, Administration and Public issuance of Virtual Assets through Mobile App & Online Platforms.

SOA, Version: 1.0; Dated: 27/08/2024

Certificate No.	**:BQUSxxxxx**
Initial Registration Date	**:20/08/2022**
Registration Date	**:19/10/2024**
Issue Date	**:21/10/2024**
Expiry Date	**:19/08/2025**
Recertification Date	**:19/08/2025**

Director

BQSR QUALITY ASSURANCE PVT. LTD.

USA Office: 183 Broadway, Ste 210 Hicksville, New York NY 11801, USA
India Office: A- 1203, Green Olive, Hinjewadi Phase 1, Pune , India

BQSR

UNITED STATES ACCREDITATION USAC

For verification and updated information concerning the present certificate, please visit www.bqsrcert.com The Certificate is valid for period of 3 years subject to satisfactory annual surveillance audit. This Certificate is the property of BQSR Quality Assurance Pvt. Ltd., & shall be returned immediately when demanded.

COMPLEX

Mongol NFT

© 2024